

# ТӨСӨВ

## ҮНДСЭН ОЙЛГОЛТ



Би аав, ээж хоёрыг "гэр бүлийн төсөв" гэж ярьж байхыг сонсож байсан.

Тэгвэл "төсөв" гэж юу вэ?



### ГЭР БҮЛИЙН ТӨСӨВ

Манай гэр бүл төсвөө хамтдаа төлөвлөж гаргадаг.



Айл гэрийн мөнгөн орлого, зарлага, хуримтлалын төлөвлөгөөг **ГЭР БҮЛИЙН ТӨСӨВ** гэнэ.

Гэр бүлийн орлого, зарлагыг тооцож, төсөвлөх нь гэр бүлийн гишүүд бүгд сэтгэл ханамжтай байх, хүртээмжтэй хуваарилалт хийх, хуримтлалыг бий болгох ач холбогдолтой юм.

Төсвийг гэр бүлийн гишүүдийн хэрэгцээнд хуваарилах мөнгөний тооцоолол, төлөвлөгөө гэж ойлгож болно.

### ОРЛОГО

Аав, ээжийн цалин, Хүүхдийн мөнгө, эмээ, өвөөгийн тэтгэвэр, ажил үйлчилгээ эрхэлсний орлого, бусад нэмэлт орлого


### ЗАРЛАГА

Гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангахад зарцуулж буй мөнгө

### ХУРИМТЛАЛ

Ирээдүйн хэрэгцээнд зориулан хадгалж, хуримтлуулсан мөнгө





Гэр бүлийн гишүүдийн нас, хүйс, боловсрол, эрхэлж буй ажил, мэргэжил зэргээс хамаараад гэр бүлийн орлого харилцан адилгүй эх үүсвэрээс бүрддэг.

Зарим гэр бүлийн орлого зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос бүрддэг бол заримынх нь бизнесийн, түрээсийн гэх мэт олон төрлийн орлогын эх үүсвэртэй байна. Харин орлогоо гэр бүлийн янз бүрийн хэрэгцээнд зарцуулна.

## [ УЛСЫН ТӨСӨВ ]

Гэр бүлд төсөв байдаг шиг манай улсад ч мөн төсөв бий. Улсын төсөв татварын болон бусад орлогоос бүрдэнэ. Хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэгтэй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй байгууллага, иргэн бүр татвар төлнө.

Боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, нийгмийн халамж, зам, байшин барилга барих, үйлдвэр зэрэг улс оронд хэрэгтэй зүйлд улсын төсвийг зарцуулна. Жишээ нь: Шинээр сургууль, цэцэрлэг барих, Хүүхдийн мөнгө, багшийн цалин, та бүгдийн суралцаж буй анги танхимын гэрэл, цахилгаан, дулаан, ном сурах бичиг зэрэгт зарцуулна.



## УЛСЫН ТӨСӨВ



УЛСЫН ТӨСӨВ гэдэг нь улсын санд хуримтлагдсан нийт орлого, түүнийг зарцуулах арга хэмжээг багтаасан орлого, зарлагын тэнцэл юм.

Улсын Их Хурал улсын жилийн төсвийн төслийг хэлэлцэн, жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор баталдаг. Мөн баталсан төсвийн гүйцэтгэлдээ хяналт тавьдаг.





Тэгэхээр Улсын төсөв бидний аав, ээжийн төлсөн татвар болон улсын бусад орлогоос бүрдэж, эргээд манай улс, иргэдэд хэрэгтэй олон зүйлд зарцуулагддаг юм байна.

Яг л бидний аав ээжийн цалин гэр бүлийн орлого болж, түүнийг гэр бүлдээ хэрэгтэй хоол хүнс, байр, эрүүл мэнд, боловсрол зэрэгт зарцуулдаг шиг. Мөн гэр бүлийн төсвийг гэр бүлээрээ хэлэлцэж төлөвлөдөг шиг улсын төсвийг ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурал хэлэлцэж баталдаг.



## ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?



Мөнгө бол бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрт төлж болох санхүүгийн хэрэгсэл юм.

Мөнгө үүсэхээс өмнө худалдаа наймаа нь барааг бараагаар солих аргаар буюу "бартер"-ийн аргаар явагддаг байжээ. Өөрөөр хэлбэл загасчин будаа авахдаа загасаа будаагаар сольж авдаг байсан бол тариачин өндөг авахдаа будаагаа өндгөөр сольдог байжээ. Үүнийг "Бартерийн тогтолцоо" гэж нэрлэдэг.

Хүн төрөлхтөн металл олборлож эхэлснээр зэс, мөнгө, алт зэрэг металлаар хийсэн зооснууд дэлхий дахинд арилжааны хэрэгсэл болон өргөнөөр хэрэглэгдэж байлаа.

Тан улсын үед (618-907) худалдаачид зоос хэрэглэхийн оронд итгэмжлэгдсэн зуучлагчаар дамжуулан том хэмжээний наймаа хийдэг болж, харин зуучлагчид цаасан дээр худалдаачны төлөх төлбөрийн хэмжээг баталгаажуулсан бичиг өгдөг болжээ.

Төлбөрийн баталгаа болсон уг цаасыг ашиглан шууд бараа худалдан авч болдог байжээ.



Үнэхээр сонирхолтой юм аа.







Энэ бол дэлхийн хамгийн анхны цаасан мөнгө «жяози» юм.

Сүн улсын (960-1279) эхэн үед хүмүүс зоосны оронд цаасан баримт авдаг болж, уг цаасан баримтаараа арилжаа хийх болжээ. Ингээд 1100 оны үед Сүн улсын төр өөрөө энэ цаасан баримтыг хэвлэх болж, дэлхийд хамгийн анхны ТӨРӨӨС хэвлэсэн цаасан мөнгийг гаргах болжээ. Уг дэвсгэртийг жяози хэмээн нэрлэж байв.



Бидний өвөг дээдэс эзэн Чингис хааны үе залгамжлагчид тэртээ Монголын нэгдсэн гүрний үеэс алт, мөнгө, зэс, гууль, хүрэл зоосыг цутгаж, цаасан мөнгийг хэвлэн гүйлгээнд гаргаж, эд баялгаа тооцоолж, гадаад гүрнүүдтэй худалдаа наймаа хийж байсан түүх бий.

Үүнээс гадна Монгол оронд мал, арьс шир, хадаг, цай зэрэг зүйл мөнгөний үүргийг гүйцэтгэж байжээ.

Оросын И.М.Майскийн Монголч эрдэмтэн тодорхойлсноор, 1919 онд дараах жишгийг ардууд өөрсдийн худалдаанд ашиглаж байжээ.

Жишээ нь: 1 гүү = 12 төлөг, 1 морь = 15 төлөг, 1 шар = 32 төлөг гэх мэт.



1 ШАР  
(6+ насны эр үхэр)

32 ТӨЛӨГ  
(2 настай хонь)



1925 оны 1 төгрөгийн дэвсгэрт

1925 онд мөнгөний шинэчлэл хийх тухай түүхэн тогтоол гарч анхны 1,3,5,10,25,50,100-тын дэвсгэртээс бүрдсэн нийт 200.100 /хоёр зуун мянга нэг зуу/ төгрөгийг гүйлгээнд оруулж байсан.

Үндэсний шинэ мөнгөн тэмдэгтээр 900 сорьцтой 18 грамм жин бүхий цагаан мөнгөн зоосыг батлан гаргаж "ТӨГРӨГ" гэж нэрлэсэн түүхтэй.






## ТҮЛХҮҮР ҮГ



- ✓ Мөнгө
- ✓ Арилжаа
- ✓ Төсөв
- ✓ Орлого
- ✓ Зарлага
- ✓ Хуримтлал
- ✓ Төгрөг



## ДАСГАЛ АЖИЛ



**МАНАЙ ГЭР БҮЛИЙН ТӨСӨВ**  
Өөрийн гэр бүлийн өрсөв болон зарлагыг сударласан бичээ үү!

**ОРЛОГО**

--	--	--

**ЗАРЛАГА**


Овог, нэр \_\_\_\_\_ Ангш \_\_\_\_\_

**Боловсрол**

Дасгалын талбарт өөрийн гэр бүлийн төсвийг төлөвлөн бичээрэй!



## ХЯНАЛТЫН АСУУЛТ



1. Танай өрхийн орлого хэрхэн бүрддэг вэ?
2. Танай өрхийн зарлага хэр их вэ? Юунд зарцуулдаг вэ?
3. Улсын төсөв гэж юу вэ?
4. Улсын төсвийг хэн баталдаг вэ?